



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 0139

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1, Сангийн сайдын 2012 оын 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шийдвэр гаргах үүрэг бүхий Улсын онцгой комиссын зүүн аймгуудад ажиллах "Шуурхай бүлэг" болон Мерси Кор Монгол, Каритас Чех олон улсын байгууллагуудын удирдлага, ажилтнуудын бүрэлдэхүүнтэй хоёрдугаар бүлэг Хэнтий аймагт 2017 оны 1 дүгээр сарын 16-наас 18-ны хооронд ажиллахтай холбогдуулан 4332110 /дөрвөн сая гурван зуун гучин хоёр мянга нэг зуун арван/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

Хоёр. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

Гурав. Хөрөнгө зарцуулалтанд шаардагдах зардлыг Засгийн газрын 2016 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан орон нутагт олгогдсон зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засагдаргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

02 283

Аймгийн Засаг даргын 2017 оны  
... дугаар сарын ... өдрийн ...  
дугаар захирамжийн хавсралт



### Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Бүгд үнэ /төгрөг/
1.	Хоол	2,589,140
2.	Хүнс	514,470
3.	Шатахуун	581,000
4.	Бэлэг дурсгал	628,500
5.	Материалын зардал	19,000
6.	<b>Дүн</b>	<b>4,332,110</b>